



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ



2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



1.2024-2025 оны хичээлийн жилд “Сургуулийн цагдаа”
эргүүлийн ажиллах журмыг мөрдөж ажиллах.

Хугацаа: Тогтмол





Биелэлт: БГ

"Сургуулийн цагдаа" хөтөлбөрийг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэхтэй холбогдуулан 2024 оны 09 дүгээр сарын эргүүлийн хуваарийг гаргасан.

Эцэг эх, асран хамгаалагчдад уг хөтөлбөрийг хуваарийн дагуу хэрэгжүүлэх, сургууль, цэцэрлэгийн автомашины зогсоолыг үйлчлүүлэгчдэд зориулан ашиглуулах зэрэг чиглэлийг боловсролын салбарын нэгж байгууллагуудад өгч, хяналт тавин ажиллаж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна



2. Сургууль, цэцэрлэгүүдийн хоол үйлдвэрлэлт, хүнсний аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж ажиллах.

Хугацаа: Тогтмол





Биелэлт: ХХААГ

Бүх шатны боловсролын сургалтын байгууллагуудын 2024-2025 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл, үйл ажиллагаанд Боловсролын газар, Эрүүл мэндийн газрын улсын байцаагчтай хамтран 1, 15, Урлагийн сургуулиудын үдийн хоол хөтөлбөр, хоол үйлдвэрлэлийн технологийн шат дараалал, зориулалтын тоног төхөөрөмжийн хангамж хүрэлцээ, мэргэжлийн тогооч, хоол зүйчтэй эсэх, ажлын байрны нөхцөл шаардлага, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Хяналт шалгалтаар бараа бүтээгдэхүүний хангамж, татан авалт дутуу, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай аж ахуйн гэрээ байгуулаагүй, гал тогооны засвар үйлчилгээ бүрэн хийгдэж дуусаагүй зэрэг 24 зөрчил илрүүлснийг газар дээр 17 зөрчлийг арилгуулж, хугацаатай үүрэг даалгавар өглөө. Хяналт шалгалт 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэл үргэлжилнэ.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна



3. Хотын дотор баригдаж буй барилга байгууламжуудын эвдэрхий хашаануудыг цэгцлэх, хог хаягдал, гэрэлтүүлэг, гэрлийн шон, бохир усны худгийн таг, явган хүний болон нийтийн эзэмшлийн зам талбайг засч янзлах, нийтийн тээврийн маршрут, цагийн хуваарийг мөрдүүлэх талаар ажлын хэсэг байгуулж ажиллах.

Хугацаа: Ойрын хугацаанд

МАИРАМДАА - ДУУЖДА



Биелэлт: ХБТХОХ

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.2, Автозамын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.4 заалтыг тус тус үндэслэн ажлын хэсгийн захирамжийн төслийг боловсруулж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна





4. 2А хороололд хийгдэж буй авто замын шинэчлэлийн ажилтай холбоотойгоор замын трасс дээр олгогдсон газар эзэмших эрхийг цуцалсан тул хашааг буулгах арга хэмжээг авч ажиллах.

Хугацаа: 08 дугаар сарын 28-ны дотор





Биелэлт: ГХБХБГ

Орхон аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/587 дугаар захирамжаар "Рапит харш" ХХК-ийн Баян-Өндөр сумын Оюут баг, 2А хороолол дахь орон сууцны зориулалт бүхий 48764 м² газрын эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон.

Тус компанийн эзэмшиж байсан газар дээр барьсан хашаа болон нийтийн эзэмшлийн зам талбайг Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4 дахь заалтыг үндэслэн албадан чөлөөлөх арга хэмжээ авахаар ажиллаж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна



5. Авто замын хучилтууд эхэлж байгаатай холбоотойгоор зам түр хаах зохицуулалтын талаар иргэд олон нийтэд мэдээлэл өгөх.

Хугацаа: Ойрын хугацаанд






Биелэлт: ХБТХОХ

Зам түр хаах мэдээллийг
аймгийн ЗДТГ, ХББЗА-ны веб хуудас,
хэвлэл мэдээллийн хэрэгслээр
иргэдэд хүргэж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна





6. Гэр хорооллын авто замын засварын ажлыг хуваарийн дагуу эхлүүлэх

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: ХЗА

Гэр хорооллын сайжруулсан шороон замыг засварлах ажлыг Баян-Өндөр сумтай хамтран 18 багийн 190 гудамжны замд хайрга асгах, автогрейдрээр хусаж тэгшлэн засварлах ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна





7. Хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээний шинэ маршрутыг дахин нягтлаад, өөрчлөх эсэх талаар санал танилцуулах.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: ХБТХОХ

Хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээний шинэ маршрутыг өөрчлөх асуудлаар АТТ-тэй хамтран санал боловсруулж, танилцуулахаар ажиллаж байна.

Хэрэгжилт: Хэрэгжих шатандаа





8. Авто вокзал шинээр ашиглалтад орж байгаатай холбоотойгоор ЭДЦС ТӨХК-ийн урд талд, А1001 замын арын хэсэгт байгаа газар дээр авто зогсоол барих тооцоо, судалгааг хийж төсвийг яаралтай танилцуулах.

Хугацаа: 08 дугаар сарын 28-ны дотор





Биелэлт: ХБТХОХ

ЭДЦС ТӨХК-ийн урд тал, А1001 замын арын хэсэгт авто зогсоол барих ажлын даалгаврыг боловсруулах, батлуулах ажлыг хийж байна. Тус ажил хийгдсэний дараа зураг төсвийг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэхээр санал авах албан тоотыг хүргүүлээд байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна





9. Авто замын бродюр сольж байгаатай холбоотойгоор эвдрэл багатай бродюр болон явган замын хавтангуудыг зарим засварлах шаардлагатай газруудад нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: ХЗА

2024 онд шинээр хучилт хийгдэх 50 байршлын авто замын бродюрыг шинэчлэхээс 20 байршлын бродюрыг гүйцэтгэгч компани хуулсан боловч ХТГ-т хүлээлгэн өгөөгүй байна. Сольсон бродюрыг хүлээлгэн өгсний дараа бусад хэсгийн засварыг хийж гүйцэтгэнэ.





10. Орхоны гүүрээс Хөшөөтийн даваа хүртэлх авто замын нөхөөсүүдийг даруй засч янзлах.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: Орхон АЗЗА ТӨХК

Өнөөдрийн байдлаар А1001 авто замд 6000м² талбайд ээлжит засварын суурь солих ажил хийгдэж байна. 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор халуун асфальтаар нөхөх ажил хийгдэнэ. Мөн угаагдсан хөвөөг сэргээж засварлах ажил 170.0 мян.м² талбайд, даралтаар шүрших аргаар 1500 м² газрын нүхэн эвдрэлийг засварлаад байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна

НАЙРАМДАА - ДУУЖДА



11. Хөх Монгол цогцолборын гадна хашааг нээж амралт чөлөөт цагийн талбай болгох зураг төслийг танилцуулах.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: ХББЗА

"Хөх Монгол цогцолборын гадна тохижилтыг засварлах" ажлын зураг төсвийг 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 428 дугаар албан бичгээр аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлсэн.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна





12. Эрдэнэ багт баригдаж буй эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны талаарх мэдээллийг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулах.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: ХББЗА

Эрдэнэ багт баригдах эрчим хүчний хэмнэлттэй 37 айлын амины орон сууцны төслийн үе шатны ажлуудад ажлын төлөвлөгөө боловсруулан тухай бүр иргэдэд мэдээлэл хүргэхээр төлөвлөж байна.

Хэрэгжилт: Хэрэгжих шатандаа





АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

2024 он

НАЙРАМДАА - ДРЧУЖДА

